

АРДЧИЛСАН НИЙГЭМ ДЭХ БИЕ ХҮНИЙ СЭТГЭЛ ЗҮЙ, ТӨЛӨВШИЛ

Д.Отгончимэг

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн докторант

Сэтгэл зүйн үүднээс нь бие хүнийг П.Олпорт: “Бие хүн нь тухайн хүний сэтгэхүй, зан байдлыг өвөрмөцөөр тодорхойлсон амьдралын явцад төлөвшин бүрэлдсэн бие хүний сэтгэл зүй, физиологийн тогтолцооны нийлбэр цогц”¹⁵³ тодорхойлсон нь нийгмийн харилцаанд орох явцад уг хүний бүрэлдсэн төлөвшсөн орчин, эзэмшсэн боловсрол, зан үйл, сэтгэл зүй ихээхэн хамааралтай.

“Бие хүн нь сэтгэл судлалын харьцангуй нарийн, төвөгтэй судалгааны асуудал бөгөөд илэрхий утгаараа бие хүн нь сэтгэл судлалын бүх л асуудлыг өөртөө бүхэл зүйл зүйл болгож зангиддаг учраас ямар ч асуудал бие хүнтэй холбоотой”¹⁵⁴ гэж тодорхойлдог. Хүн насан туршдаа ямар нэг үйл ажиллагааг ямагт эрхлэж байдаг. Хүн хэдийчинээ олон төрлийн үйл ажиллагаанд оролцоно, төдийчинээ хүн хөгжиж төлөвшиж, авьяас сэтгэлгээний цар хүрээ нь тэлж байдаг. Жишээ нь:

Насанд хүрсэн хүний үндсэн үйл ажиллагаа нь хөдөлмөр юм. Хөдөлмөрийн үр дүнд хүн өөрийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангаж, материал баялагийг үйлдвэрлэх явцад өөрөө хөгжиж, бие хүний үндсэн шинж чанарууд хөгжин төлөвшинө.

“Сэтгэл судлаачдын тайлбарласанаар хүний үйл ажиллагааны үндсэн төрлүүд болох тоглох, сурах, хөдөлмөрлөх үйл”¹⁵⁵ нь ямар сургалтын гол зүйл болж өгдөг. Өөрөөр хэлбэл сургалтын орчинд хувь хүн өсөн хөгждөг. Үүнд бие хүний хөгжилд хүчтэй нөлөө үзүүлдэг өөр нэг хүчин зүйл бол нийгмийн орчин юм. Нийгмийн орчин гэдэг ойлголт нь юуны өмнө хүмүүс, тэдгээрийн хөдөлмөрийн болон нийгмийн амьдрал, зан заншил, ёс суртахуун, улсын хууль дүрэм, ном хэвлэл, кино, хүмүүсийн нэгдсэн шаардлага, төрх байдал, зан араншин, гоо зүйн байдлыг оролцуулна.

Бие хүн төлөвших дараахи зүй тогтол байна.

- а) Бие хүний төлөвшил нь гадаад, дотоод хүчин зүйлүүдээс хамаарч байдаг.
- б) Бие хүн нийгмийн харилцаанд оролцож байж төлөвшинө.
- в) Бие хүн үйл ажиллагаанд оролцож төлөвшдөг зүй тогтолтой.

Бие хүн төлөвшихөд нөлөөлөх хүчин зүйл. Бие хүний төлөвшил хүний төрөлхийн шинж чанар, өөрийн хүсэл, сонирхол, хичээл зүтгэл болон байгаль нийгмийн орчин, сургалт хүмүүжлээс их хамаарна. Хүн эхээс мэндлэхдээ бие махбодь, сэтгэцийн хувийн онцлог чанарууд, зан төлөв, темперамент, авьяас билэг нь эцэг эхээсээ удамшдаг тал бий гэж судлаачид, мөн сурган хүмүүжүүлэгчид үздэг.

¹⁵³ Даваа.Ж, Жамц.Л, Содов.Ц, Сүхбат.Г. Боловсрол судлалын үндэс. Боловсролын хүрээлэн. Орхон Их Сургууль. УБ.2009. х-61

¹⁵⁴ Сарантуяа.Г. Сэтгэц оношлогоо. УБ.2001.х-70.

¹⁵⁵ Дэлгэржав.М. Багшийн мэргэжил дээшлүүлэх асуудалд. УБ.2006.х-16

“Хүн хүнтэйгээ харьцах ёс суртахууны үнэт чанарыг эзэмшүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн харилцааны бүхий л хүрээнд мөрддөг хэм хэмжээг ухамсарлуулах үйл ажиллагаа болон түүний үр дүнг **ёс зүйн боловсрол**”¹⁵⁶ гэнэ. Ёс зүй гэдэг ойлголт маань өөрөө (ethica) ёс суртахууны үүсэл, хөгжлийн зүй тогтол, зарчим, хэм хэмжээ, ойлголт, хүний эрхэм чанарыг судалдаг ухаан билээ. Тиймээс бие хүн төлөвшихөд үйл ажиллагааны тоглох, сурах, хөдөлмөрлөх, биеийн тамир спорт, урлаг, уран сайхны бүх төрлүүдийг зөв зохион байгуулах нь нэн чухал.

Хүн нийгмийн амьтны хувьд хүрээлэн байгаа ертөнцийг ухамсартайгаар тусган авах төдийгүй түүнийг өөрийн хэрэгцээ сонирхлын дагуу бүтээлчээр хувьсган өөрчилж, хамгаалах чадвартай. Хүн гэж сүүн тэжээлтний ангид багтдаг биологийн нэгэн амьтан, онцлог шинж нь хөл дээрээ явдаг, хөдөлмөрлөдөг, дээд зэргийн хөгжилтэй уураг тархитай байдаг оршдог.

“Хүний амьдралын үйл ажиллагааны явцад аажим аажмаар бүрэлдэн тогтсонзан суртахууны хэм хэмжээ, ёс заншил нь хүн хүнтэйгээ харилцах харилцаанд илрэлээ олж, хүний ухамсарт тусдаг”¹⁵⁷. Энэ нь нийгмийн хөгжлийн явцад хүн бүрийн заавал мөрдөх хууль болдог бол ёс суртахууны үнэлэмжийн ухамсар урлаг, шашинтай салшгүй холбоотой байдаг. Тиймээс ч ёс суртахууны ухамсар гэдэг бол хүмүүс бие биетэйгээ, нийгэмтэйгээ харилцах хэм хэмжээ, үнэлэлт, ойлголт, зарчмуудын нийлбэр болж байдаг. “Хүн өөрийгөө илэрхийлэн уран илтгэж сурах, шинжлэх ухааны сэтгэлгээний соёл эзэмших”¹⁵⁸ нь цаашид нийгэмд өөрийгөө таниулах үндсэн суурь болж өгдөг.

Бие хүний ёс суртахууны ухамсарыг бүрдүүлж байгаа /үүрэг, хариуцлага, нинжин сэтгэл, хүнлэг эрхэм чанар/ бүхэн тодорхой хэмжээний сэтгэл хөдлөлөөр /бахархах, атаархах, биеэ тоох, айх, ичих, уурлах, өрөвдөх/ гэх мэтээр илэрдэг билээ.

А.Маслоугийн /Moslow/ үзэж байгаагаар бол хүн амин чухал биологийн хэрэгцээгээ хангаж байж сая өөрийн нөөц чадавхи боломжоо бүтээлчээр илэрхийлэх, харуулах нөхцөл бий болдог байна. Эхлээд заавал хангахгүй бол цаашид бэрхшээл учруулж болох (идэж уух, унтах гэх мэт) биологийн хэрэгцээ бол хүний суурь тулгуур хэрэгцээ юм. Үүний дараагаар хамгаалагдах (толгой хорогдох орон байртай байх, халамжлуулан асруулах, аюулаас зайлсхийх гэх мэт) хэрэгцээнүүд бий болдог. Эдгээр хэрэгцээнүүд зохих хэмжээнд хангагдсанаар хүнд тодорхой хамт олны харъяалалд багтаж хайрлагдах, хайрлах, найз нөхдөөрөө бахархах нийгмийн хэрэгцээгээ хангах нөхцөл бүрдэнэ. Эдгээр хэрэгцээ хангагдаж чадвал бүтээлчээр эрэл хайгуул хийх, өөрийн авъяас чадвар, хүч нөөцийг дайчлан амжилтанд хүрэх, алдар нэр хүндтэй болж өөрийгөө харуулах эрхэм дээд хэрэгцээ хүнийг хөтлөн жолоодож, хөгжлийг урагшуулуулдаг. Хэрэгцээ – бие хүн ямар нэгэн зүйлд гачигдал амсах явдал юм. Хүний хэрэгцээ амьтдынхаас ямар нэгэн хэмжээгээр тогтвортой,

¹⁵⁶ Золзаяа.Б//МУИС-НШУС. Боловсрол судлал. УБ.2005.07(255)х-11

¹⁵⁷ Золзаяа.М. Ёс зүй. УБ.2005.х-84

¹⁵⁸ Даваа.Ж//МУИС-НШУС. Боловсрол судлал. УБ.341(2010.01) х-51

хязгаарлагдмал, голчлон биологийн гачигдлаас ялгаатай бөгөөд түүний амьдралын туршид цаг ямагт өөрчлөгдөх ба олширсоор байдаг. Хүний нийгэм өөрийн гишүүдэд урьд байгаагүй шинэ шинэ хэрэгцээг бий болгосоор байдаг. Хэрэгцээний энэхүү байнгын шинэчлэлд нийгмийн үйлдвэрлэл багагүй үүрэг гүйцэтгэдэг: хэрэглээний улам бүр шинэ шинэ юмс хийж бүтээснээр хүмүүсийн амьдралд шинэ хэрэгцээг үүсгэдэг.

Хэрэгцээний өвөрмөц онцлог:

1. Хүмүүсийн эзэмших гэж эрмэлзсэн юмс, эсвэл хүнд ханамжтай сэтгэлийг төрүүлэх ёстой ямар нэгэн үйл ажиллагаа /жишээ нь тодорхой ажил, тоглоом гэх мэт/-тэй хэрэгцээний тодорхой агуулга гол төлөв холбоотой.
2. өвөрмөц шинж байдал бүхий сэтгэлийн хөдөлгөөний доголдсон тухайн хэрэгцээг их буюу багаар тодорхой ухамсарлах /тухайн хэрэгцээтэй холбоотой объектийн сэтгэл татам байдал, тааламжгүй гэх мэт/,
3. хэрэгцээг хангах арга замыг эрж хайхад чиглүүлэх сулавтар ч ухаарал гол төлөв байдаг боловч сэтгэл хөдлөл-зоригийн байдаг ямагт байдаг,
4. сулрал заримдаа бүрмөсөн алга болох ба урьд нь хэрэгцээгээ хангасан зарим тохиолдолд тэдгээр нь огт эсрэг байдал болж хувирна. /жишээ нь хэтэрхий их цадсан үед хоол харахад дургүй хүрэх мэдрэмж үүсдэг/,
5. давтан үүсэх хэрэгцээ нь түүний эх үүсвэр байсан гачигдал дахин сэргэх үед гарна¹⁵⁹.

Бие хүний сэтгэл зүйн тал нь: түүний сэтгэцийн процесс, шинж, байдал ба бүрдлийн онцлогийг тусгадаг. Үүнд:

- ✓ “бие хүний ертөнцийг үзэх үзлийн тал- нь нийгэмд зохих байраа эзлэх боломж олгох олон нийтийн ач холбогдол бүхий чанар ба онцлогийг тусгадаг,
- ✓ бие хүний ертөнцийг үзэх үзэл- ухамсар, амьдралын тодорхой зорилго ба сонирхол, хандлага, байр суурь хэлбэрээр хадгалагдан хуримтлагдсан ба түүний дотоод баялаг болсон тогтож бий болсон систем болно,
- ✓ бие хүний зан суртахууны төрх- нийгэм дэх зан үйл, үйлдлийг тодорхойлогч ба түүнд хатуу тогтсон хэвшлийн тусгагч зан суртахууны талаар төсөөллийн систем юм,
- ✓ бие хүний ёс суртахууны төрх- нийгэм дэх хүмүүсийн харьцааны хэм хэмжээ ба тэдний зүй зохистой харилцан үйлдэлд хандах үзэл бодлын тогтвортой систем,
- ✓ бие хүний нийгэм сэтгэл зүйн тал нь- нийгэмд тодорхой үүрэг гүйцэтгэх, бусад хүмүүсийн дунд тодорхой байр суурь эзлэх

¹⁵⁹6-р бүлэг. "Бие хүний сэтгэл зүй"//Сэтгэл судлал. Практик сэтгэл судлалын номын сан. УБ.2002.х-162

боломж олгож, бие хүний үндсэн чанар ба шинж байдлыг тусгадаг,

- ✓ бусад хүмүүст хандах хандлага- бие хүний зан үйлийн харилцаанд ба бусад хүмүүстэй харилцан үйлдэхэд тусгагч, хувийн ба нийгэм-сэтгэл зүйн илрэлийн цогц юм.
- ✓ бие хүний нийгмийн дүр- бусад хүмүүсийн зүгээс тодорхой нэр хүнд ба итгэлийг байлдан дагуулах боломж олгогч хувийн ба нийгэм сэтгэл зүйн онцлогоор нөхцөлдөгч бие хүний зан үйлийн ердийн арга юм,
- ✓ бие хүний /нийгмийн/ байр суурь- нь бусад хүмүүстэй харьцах харьцаандаа хэрэгжүүлэн хамгаалдаг бие хүний үзэл бодол, итгэл үнэмшил ба төсөөлөл юм,
- ✓ бие хүний /нийгмийн тогтсон хандлага- бусад хүмүүст болон нийгэмд хандах сэтгэл санаа юм¹⁶⁰.

Бие хүн гэж нийгмийн өмнө үүрэг хариуцлага хүлээж, тодорхой зорилго чиглэлтэй үйл ажиллагаа явуулж, нийгэм хамт олонд хэвийн тогтсон хэв хэмжээнд захирагдаж, бүтээлч үйл ажиллагаа явуулж, нийгмийн гишүүний хувьд тодорхой байр суурь эзэлж байдаг хүнийг бие хүн гэнэ.

Бие хүн гэдэг бол нэг хүн, давтагдашгүй хүн, өвөрмөц онцлог хүн гэсэн үг юм. Хүн мэндлэхдээ хувь хүн гарна. Цаашдаа бие цогцос, оюун ухаан, чиг зорилтоо хөгжүүлж жинхэнэ хүн болдог. Товчоор хэлбэл, улс нийгмийн үнэ цэнэтэй гишүүн болно. Үүнийг хувь хүн нийгэмшлээ гэнэ. Нийгэмшсэн хүнийг бие хүн боллоо гэнэ. Тиймд ухамсарт нь амьдралын тодорхой зорилго, хандлага, байр суурь байдлаар хадгалагдсан дотоод баялаг ба нийгэм, хүмүүсийн харьцаа, байгальд хандах шинжлэх ухааны үзэл бодол, итгэл үнэмшлийн тогтож бий болсон систем болдог ч бие хүний тогтсон хандлага нь алив нэгэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эсвэл өөрийн хувийн идэвхийг зогсоон саатуулах дотоод хөг болдог. Тогтсон хандлага нь тодорхой үйл ажиллагааг үр бүтээлтэй биелүүлэх боломж олгох бэлэн байдал бөгөөд үйл ажиллагааны чанарт чухал ач холбогдолтой асуудал юм. Тэдгээрийн үндсэн үүрэг нь:

1/үйл ажиллагааны явагдах тогтвортой шинж байдлыг тодорхойлох,

2/бие хүнийг шийдвэр гаргах ба стандарт нөхцөл байдал дахь үйл ажиллагааны явцыг нь зориуд хянах эсвэл шаардлагаас чөлөөлөх,

Бие хүнд ихээхэн ач холбогдол бүхий юмс, үзэгдэл, үүрэг, зорилт, объект бөгөөд үүнд хүрэх ба эзэмших нь түүний амьдрал, үйл ажиллагааны гол утга учир болдог учраас бие хүний хэрэгцээг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эцсийн үр дүн байдлаар гарч ирдэг.

Ерөнхий бие хүний төлөвшлийг олохын тулд хүүхдээс нь хүмүүжүүлэх нь чухал. Тиймээс "Ш.А.Амонашвилийн хүмүүнлэг бие хүнд чиглэсэн технологи зорилгот:

- ✓ хүүхдийн бие хүний чадварыг нээх замаар, энэрэнгүй хүн болон хөгжиж, хүмүүжин бүрэлдэхэд нөлөөлөх

¹⁶⁰ Мөн тэнд .х-158

- ✓ хүүхдийн зүрх сэтгэлийг ариун байлгах
- ✓ хүүхдийн танин мэдэх хүчийг хөгжүүлж, төлөвшүүлэх
- ✓ мэдлэг чадварыг тэлэх болон гүнзгийрүүлэх нөхцлийг бүрдүүлэх
- ✓ өөрийгөө хүмүүжүүлэх нь хүмүүжлийн эрхэм зорилго байх”¹⁶¹

Бие хүний хөгжил. Хүн бол хөгжил дэвшлийг тээн явагч мөн. Түүний үйлдэл, сэтгэлгээ бүхэн ямагт шинэ байна. Үл давтагдах энэ чанар хүнээс өөр амьдралд байхгүй. Шинэ бүхэн нь хөгжил авчирна. Хөдөлмөр бүтээл сайжирч, хөгжил боловсронгуй болно.

Бие хүнд улс төрийн нийгэмшилтийг олгохын тулд иргэний эрх, улс төрийн эрхийг ард түмэндээ эдлүүлэх, ингэснээр улс төрийн эрх, иргэний эрхээ бататгахын тулд иргэний үүрэг, хариуцлагыг өөртөө хүлээдэг. Энгийн үгээр тайлбарлавал: эдгээр хариуцлага нь нийгмийн улс төрийн үйл явцад оролцох нөхцөл бололцоог олгож байгаа юмаа.

Бие хүнд хүн өөрөө нийгмийн харилцаанд орох, төрөөс улс төрийн нийгэмшилтийг олгох угтвар нөхцөл нь иргэдэд субъектив эрхийг олгох явдал нь чухал юм.

Бие хүн төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй, ижил эрхтэй байдгийг Тунхаглал цохон тэмдэглэсэн буй. Хүн бүр арьс өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн хийгээд бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, хөрөнгө чинээ, анги давхарга бусад байдлын хувьд ямар ч ялгаваргүйгээр Тунхаглалд заасан бүх эрх, эрх чөлөөг эдлэх ёстой. Тэгвэл Грекийн нэрт сэтгэгч Платон улс төрийн байгууламж бүр өөрийн онцгой хэлтэй байдаг. Үүнд: “Демократид нэг хэл, Олигарихад нэг хэл, монархид бүр өөр хэлээр яримой ... өөртөө заяасан хэлээр яривал төр цэцэглэн мандана. Хэрэв бусдын хэлийг дуурайдаг тийм төрийн байгууламж мөхдөг¹⁶² гэсэн сонирхолтой бөгөөд мэргэн ухааныг бодууштай. Бид бусдын хэлийг дуурайж ярихын зовлонг зуур зуур амсан байснаа мартаж болохгүй бөгөөд “Айлаас эрэхээр авдараа уудал” хэмээх дээдэс буурлынхаа ухааныг дээдлэх нь онолын хийгээд практик ач холбогдолтой билээ.

Онолын хувьд иргэний нийгмийн гэр бүл, төр, зах зээлээс гадуур оршдог иргэдийн эвсэлдэн нэгдэж, нийтлэг эрх ашгийгаа төлөө үйл ажиллагаа явуулдаг талбар хэмээн тодорхойлбол цаашид Төрийн бус байгууллагуудыг Иргэний нийгмийн байгууллагууд хэмээн томъёолох нь зохистой байна.

“Миний мэдэх хамгийн ухаантай, хамгийн шудрага хүнийг” цааш харуулснаараа “АРДЧИЛСАН” хэмээх төр үнэн нүүр царайгаа харууллаа¹⁶³ гэж Платон хэлжээ.

Нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны бүх салбаруудын түгээмэл бөгөөд мөнхийн ухагдахуун нь хүн, хүний хөгжил, төлөвшлийн асуудал юм.

“Хүн сэтгэл, зан төлөв, биеэ авч явах хэвшил дадлаа үйл ажиллагаараа болон зориуд төгөлдөржүүлэн сайжруулахыг өөрөө хүмүүжих гэх ба энэ нь бие

¹⁶¹ Айсмонтас.Б.Б.Сургалтын онол. /бүдүүвч, сорил. УБ.2003.х-140

¹⁶² Платон. Захидлууд. (Орчуулга. Б.Д) ED.1998.7 дах тал

¹⁶³ “Дэлхийн түүхийн суут 100 хүн. Майкл Х.Харт. (Орч. Д.Өлгийсайхан)УБ.2010.х-80

хүний үндсэн шинжийн илрэл юм. Өөрөө хүмүүжих нь хүний сэтгэхүйн ба бие бялдрын хөгжлийг түргэсгэж, ёс суртахууны эерэг шинж чанаруудыг төлөвшүүлдгээс хүн авъяас билгээ төгөлдөржүүлэн хөгжүүлэх үндсэн нөхцөл юм. Түүнчлэн хүн өөрчлөгдөн хөгжиж буй нийгмээ соргогоор тусгаж, амьдралд өөрийн байр сууриа эзлэн, өөрийгөө нотлон харуулах нөхцөл нь болдог¹⁶⁴ гэж тодорхойлсон нь өөрөө хүмүүжих нь хүмүүжүүлэх үйл явцад их ач тустайг харуулж байгаа юм.

Хүн өөрөө хүмүүжих үйл явцдаа өөрийгөө үнэлж, дүгнэх нь өөрийн хүмүүжлийн үр нөлөөг дээшлүүлдэг. Хүн өөрөө хүмүүжихдээ:

- ✓ биеэ ажиглан шинжих
- ✓ өөрийгөө ухамсарлах
- ✓ өөрийгөө дайчлах
- ✓ өөрийгөө итгүүлэх
- ✓ өөрийгөө ятгах
- ✓ өөрийгөө урамшуулах
- ✓ өөрийгөө цэгнэх зэрэг олон арга хэрэглэдэг.

“Хүн өөрөө л хүмүүжихгүй юм бол хэн ч түүнийг хүмүүжүүлэхгүй” гэж В.А.Сухомолинский хэлсэн нь өнөөгийн зах зээлийн ороо бусгаа үед ч ач холбогдолтой хэвээр байсаар байна¹⁶⁵. Бие хүний төлөвших зүй тогтлыг харгалзан хүмүүсийн дунд хүнийг төлөвшүүлэх нь өнө эртний уламжлалтай билээ. “Авъяас чадвар ба мэдлэг, чадвар¹⁶⁶” хүнд 1%-ийн авъяас, 99%-ийн хөдөлмөр зүтгэл, мэрийлт зайлшгүй хэрэгтэй. Ялангуяа бие хүний өөрийн авъяас чадвар буюу дуртай зүйл, сайн тал дээр нь тулгуурлан ажилладаг нь манай эрдэмтэн багш нарын нөр олон жилийн хөдөлмөрийн үр шимээр өнөөгийн залуус дэлхийн давцанд монголынхоо нэрийг дуурсгаж, ахмад үеийнхэн болон төр засгаас хайр энэрэлээ хүрсээр байна.

Хөгжлийн аль ч үед эрдэмтэн мэргэд энэ сэдвийг судлаж, сургаал, номлолоо хайрласаар ирсэн билээ.

Хүний тухай асуудлыг хөндөхгүй судалгаа, бичээгүй судлаач байхгүй гэж хэлж болно. Гэвч хэн ч хүн хөгжлийн бэлэн жор боловсроогүй байна. Хүний тухай судалгааг улам бүр нарийсч, түүнд тавигдах шаардлага ассаар л байна.

Ардчилал, иргэдийн нийгмийн оролцоо, иргэний нийгэм, улс төрийн иргэншил гэсэн харилцаа уялдаа бүхий асуудлуудыг сонирхож судалгааны ажлыг хийх явцад хувь хүн төрийн үйл ажиллагаанд хэрхэн идэвхтэй оролцох, эс оролцох нь сонирхол татаж байсан. Тиймээс ч уламжлалт тогтолцоог халснаар бие хүний өсөлт хэрхэн өсөж буйг судалж байна.

Бие хүний өөрөөр хэлбэл хувь хүн улс төрийн нийгэмшилтийг хангах нь “хэнд” ашигтай вэ? гэсэн асуудал гарч ирдэг. Ер нь хувь хүн гэж хэн бэ? Үүнийг

¹⁶⁴ Программа курса психологий. Сэтгэл судлал. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон тэмдэгт Монгол Улсын Их Сургууль. УБ.1963.х-8

¹⁶⁵ Дэлхийн түүхийн суут 100 хүн. Майкл Х.Харт. (Орч. Д.Өлгийсайхан)УБ.2010.х-100

¹⁶⁶ Программа курса психологий. Сэтгэл судлал. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон тэмдэгт Монгол Улсын Их Сургууль. УБ.1963.х-8

тодорхойлохын тулд хувь хүн, бие хүн иргэн гэсэн ойлголтууд авч үзэх шаардлагатай.

“Бие хүн” гэдэг нь философийн ухагдахуун. Харин “иргэн” гэдэг ойлголт илүү практик түвшинд яригддаг.

Улс төрийн шинжлэх ухаанд бие хүн, хувь хүн гэдэг нь ойлголтууд үндсэндээ адил утгаар хэрэглэгддэг. Тэгэхлээр улс төрийн харилцаанд бие даан оролцож шийдвэр гаргах эрх, эдлэх үүрэг хариуцлага хүлээх чадварыг илэрхийлдэг ойлголт юм.

Иргэн, төр гэсэн ойлголтууд хоорондоо салшгүй холбоотой. Төр гэдэг үгийн цаана иргэн гэдэг ойлголт гүн агуулгаар илэрхийлэгддэг. Иргэн нь: “Хувь хүний эрх, эрх чөлөөг эдлэх боловч бусадтайгаа хамтран өөрийгөө захирах ёсны үндсэн үнэт зүйлийг шингээсэн ирээдүйгээ цогцлоон байгуулах хариуцлагыг хүлээдэг” учиртай.

“Иргэн” гэдэг ойлголт нь аливаа нийгмийн тогтолцооны үед харилцан адилгүй эрх, “үүрэг хариуцлаг”-ыг хүлээдэг. Иргэн хүнд анхдагч нь эрх, эрхээ эдлэх хэрэгжүүлэхийн тулд тодорхой үүргийг хүлээдэг. Төр оршин байгаа нөхцөлд бие хүн “иргэн” хүний эрх, үүргийг л эдлэх болно.

*Бие хүнийг төрөөс хараат байх нөхцөлийг хангаж байдаг хувийн өмч оршин тогтносон урт хугацаанд улс төрийн ардчилсан соёл төлөвшин үүсчээ. Ардчилсан улс төрийн соёл хувь хүнийг онцлон анхаарч, түүний чадвар, боломжийг нээхэд чиглэгдсэн байна*¹⁶⁷ гэж заасан нь нийгэмд өөрөө соёлтой иргэнийг байх ёстойг тодорхойлж байгаа хэрэг билээ.

Соёл нь хүний өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг оюуны, материаллаг болон харилцааны үнэт зүйлс, зайлшгүй дагаж мөрдөх, хэвшүүлэх хэм хэмжээ юм. Үүнд хүний болон нийгмийн амьдралын бүхий л хүрээ салбарт хамаатай тул зайлшгүй эзэмших ёстой зүйл. Соёлжино гэдэг нь соёлыг бүрдүүлж буй бүхнийг сурна, сураад зогсохгүй эзэмшинэ гэсэн үг¹⁶⁸ хэмээн нэгэн судлаач дурьдсан байна. Мөн соёл гэдэг нь хувь хүн болон бүлгийн хүрээлэн буй орчин түүнтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанаас олж авсан мэдлэг туршлагаар тодорхойлогдоно¹⁶⁹ гэсэн нь ч бий.

Харин энэхүү соёл хэмээх ойлголт нь хүний хэрэгцээ, түүнээс үүдэх хэрэглээнээс шалтгаалан олон хэлбэрт хуваагдаж байна. Жишээ нь, албан бичгийн, хэл ярианы, хувийн гэх мэт соёлууд байдаг ба хувийн соёлд: хооллох соёл, хувцаслах соёл, хэрэглээний соёл гэсэн гурван үндсэн ойлголт багтдаг байна.

Бие хүн зохион байгуулагч байх нь янз бүрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, хамт олны нэгдмэл үйл ажиллагааг хангах асуудал юм. Ялангуяа, хүмүүжлийн ажил зохион байгуулахад онцгой чухал юм. Зохион байгуулах чадварт : дайчлах, мэдээллэх, хөгжүүлэх, чиглүүлэх чадварууд орно. Үүнд:

¹⁶⁷ Базарпүрэв.С.Улс төрийн шинжлэх ухаан. Хураангуй лекц,УБ.2005.х-89-90

¹⁶⁸ СЭЗДС-ийн сэтгэл судлалын ухааны доктор, профессор Б.Оюунчимэг

¹⁶⁹ The Principles of Marketing. Phillip Kotler.

Дайчлах чадварт: хамт олныг анхаарлыг татах, үйл ажиллагаанд сонирхох, хэрэгцээг бий болгох, тэдний туршлага, мэдлэгт үндэслэн бүтээлч хандлагыг бий болгох, ёсзүйн үйлдэл хийх нөхцлийг бүрдүүлэх, сэдэлжүүлэх.

Мэдээлэх чадварт: мэдээллийг оновчтой хэлбэрээр өгөх, эх материалтай ажиллах чадвар, мэдээллийг арга зүйн хувьд боловсруулах, ярилцлага, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцоог хангах.

Хөгжүүлэх чадварт: хүүхдийн ойрын хөгжлийн бүсийг тогтоож, түүнийг одоогийн хөгжлийн бүс болгох чадвар.

Чиглүүлэх чадварт: үнэлэмжийн баримжааг тогтоох чадвар: байгаль, хөдөлмөр, нийгэм, зан үйлийн сэдэлд хандах хандлага, бүтээлч, хамтын үйл ажиллагаанд сонирхолтой болгох зэрэг.

Аливаа соёлыг дагалдаж “хэрэглээний соёл” гэдэг нь хэрэглээ, түүнтэй хамаарах соёлын талаарх ойлголт байх ёстой. Хэрэглээ гэдгийг хүмүүс ямарваа нэг бараа үйлчилгээг худалдан авсны эцэст ашиглах, зарцуулахтай холбоотой үйлдэл¹⁷⁰ хэмээн ойлгож болох. Харин соёл гэдэг нь *cultura* гэсэн латин үгнээс гаралтай ба энэ нь тариалах, хөгжүүлэх, дэлгэрүүлэх гэсэн утга санааг илэрхийлдэг байна. Соёлын талаар маш олон янзын тодорхойлолтууд бий ч, агуулгын хувьд ижил төстэй байдаг.

Нийгмийн харилцааг төгс төгөлдөр болгон төлөвшүүлэхэд ардчилсан сөрөг хүчин чухал үүрэгтэй. Гэвч ардчилсан сөрөг хүчин буулт хийхгүй бол “зөрүүлдэж”, өөрсдийн байр сууриа үнэн зөв хэмээн зүтгэх нь нийгэм-улс төрийн гишүүдэд хор хөнөөл хүргэж болзошгүй юм гэж дүгнэн тодорхойлсон байдаг.

Нийгмийн хүрээг өргөн дэлгэрүүлсэн арга замыг үндсэн 2 хэлбэрт авч үзье.

Үүнд:

1. Хувь хүн, нийгмийн янз бүрийн давхрааг багтаасан нийгмийн (социальный) Тухайлбал: мэргэжлийн, угсаатны, ам зүйн гэх мэт. Энд хувь хүн, мэргэжлийн бүлэг, үндэстэн, анги, элит зэрэг багтана.
2. Төр, нам, үйлдвэрчний эвлэл, улс төрийн хөдөлгөөн зэрэг зохион байгуулалт бүхий бүлгийн ашиг сонирхолыг хамгаалсан институтжсэн хэмээн тус тус ангилж болдог.

Хүний идэвхийн үндсэн үзүүлэлтүүд. Улс төрийн бодлогын анхдагч субъект нь төрийн бодлогын анхдагч субъект бие хүн . (индивид) юм. Нэрт сэтгэгч Претогор: “Хүн бол бүх юмсын хэмжүүр” гэжээ.

Английн түүхч Х.Ховарос “Орчин үеийн улс төрийн шинжийг бүрдүүлдэг шударга хүлээцтэй хандлага, сахилга бат, сайн үйл тэр үед Чингисийн ордонд мөрдөгдөн хэрэгжиж байв¹⁷¹ гэж тэмдэглэсэн нь ардчилсан нийгмийн шударга ёс, сахилга батыг зөв оновчтой гарган ирснийг бид санах хэрэгтэй.

Бие хүний үйл байдал улс төрийн нийгэмшлийн үйл явц бий болсон засаглалын хүчийг хүндэтгэх байдалд үндэслэгддэг гээд улс төрийн системийг

¹⁷⁰ http://en.wikipedia.org/wiki/Consumption_%28economics%29

¹⁷¹ Хенри.Ховард. History of Mongols. It 1.London.1876.,p.49

хүлээн зөвшөөрөхийг зөв бөгөөд үнэт чиг баримжаа мөн гэж тайлбарладаг.¹⁷² Улс төрийн системд хувь хүний нийгмийн үүргээр үүргийн сэдэл урьдаас тогтоогддог. Хүний үйл байдалд зонхилох үүргийн сэдэл нь түүний нийгмийн байдал, өөрөө өөрийгөө үнэлэхтэй шууд холбоотой. Бие хүний нийгмийн байр суурь бага байх тутам төрийг эсэргүүцэх хувь хүний эрс тэрс үзэл илүү их байдаг гэж үздэг.

Улс төрийн бодлогод хувь хүний оролцох шалтгааныг судлахад хүмүүнлэг сэтгэл зүй /гуманистическая психология/ төлөөлөгчид үлэмж хувь нэмрээ оруулсан юм¹⁷³ гэж үзсэн байдаг. Тэгвэл энэ чиглэлийг үндэслэгч А.Маслоу: Хувь хүнд:

1. физиологийн хэрэгцээ,
2. аюулгүй байдлаа хангах хэрэгцээ,
3. нийгэмд тодорхой байр суурь эзлэх хэрэгцээ,
4. өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ,
5. өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ гэсэн үндсэн сэдлүүд байдаг.

Эдгээр хэрэгцээнүүд нь физиологийн хэрэгцээнээс гадна өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ нь хүртэл доороос дээш шатлан оршдог. Хүний анхдагч хэрэгцээг хангагдсанаар дараагийн хэрэгцээ хангагдах болно. Энэ хандлагыг улс төрийн үйл ажиллагааны судалгаанд хэрэглэж болох талтай. Тэгэхдээ физиологийн хэрэгцээ нь амьдралын түвшингээ дээшлүүлэх хэрэгцээ болж, аюулгүй байдлаа хангах хэрэгцээ нь нийгмийн дэглэм, дэг журам хууль ёсыг эрхэмлэж, нийгэмд тодорхой байр суурь эзлэх хэрэгцээ нь нийгмийн тэгш байдлын хэрэгцээ (нийгмийн тодорхой бүлэг, нам хөдөлгөөнд хамрагдах мэдрэмж) нь болж, өөрийгөө илэрхийлэгдэх хэрэгцээнд нийгмийн байр суурь (статус) нэр хүндээ өсгөх хэрэгцээ болж, өөрийгөө хөгжүүлэх нь улс төрийн хүрээнд өөрийн үзэл сонирхлыг биелүүлэх, илэхийлэх хэрэгцээ болж хувирдаг¹⁷⁴ гэж тодорхойлсон хувь хүн тухайн амьдарч буй нийгэмдээ хэрхэн өсөн торнин өөрийн зайг олж авдгын баталгаа юм.

“Хүмүүнлэг энэрэнгүй ардчилсан манай нийгмийн хүрээнд ажиллаж амьдарч буй иргэний хувьд Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль зэрэг олон хуульд заасан эрхийг эдлэхээс гадна хүүхэд наснаас эхлэн сургууль боловсролын холбогдолтой хуулиудад заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээдэг¹⁷⁵

Бие хүн улс төрийн тодорхой үүрэг хариуцлагыг хүлээхдээ эрхээ мэдэрч, үүргээ өндөрт ухамсарлаж, төрдөө сөрөг хүч байх зарчим бүрэлдэн тогтдог. Төрд сөрөг хүч байх ойлголт нь өөртөө их олон зүйлийг агуулдаг. Жишээлбэл:

- ✓ Ширүүн тэмцлийн үрээр олсон эрх чөлөөгөө хамгаалах
- ✓ Нийтийг хамарсан хэлэлцүүлэг маргаанд санал бодлоо нэмэрлэх
- ✓ Ямар нэг үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээдэг байх
- ✓ Төлөөлөгчдөө сонгох, бас өөрсдөө сонгогдох эрхээ чөлөөтэй эдлэх, нийгэм улс төрийн амьдралд урьдынхаас илүү идэвхитэйгээр оролцож,

¹⁷² Загджав.Д. Монгол дахь иргэдийн улс төрийн оролцоо, өөрчлөлт. УБ. 2002.,х-41

¹⁷³ Мөн тэнд. х-25

¹⁷⁴ Юриев.А.И.Введениею психологию СПб.,1992.с-187

¹⁷⁵ Дэлгэржав.М. Багшийн мэргэжил дээшлүүлэх асуудалд. УБ.2006.х-60

бас хүлээцтэй, тэвчээртэй байх, иргэн бүр улс төрд анализ хийж чадах чадвартай болсон байхыг хамааруулж ойлгодог.

ДҮГНЭЛТ

Ардчилсан нийгмийн шалгуурыг хангахад бие хүний идэвхитэй үйл ажиллагаа, иргэн бүрийн өөрсдийнх нь боловсрол мэдлэг, авъяас, бие хэрхэн төлөвшүүлсэн байх хэрэгтэй. Мөн улс төрийн өндөр соёлтой байх шаардлагад нийцэж амьдрах нь чухал. Тиймээс ч иргэдийг улс төрийн нийгэмшилд татан оролцуулах нийгмийн хэм хэмжээ, зохион байгуулалт ч чухал үүрэгтэй. Нэн ялангуяа бие хүний сэтгэл зүй болон түүний авъяас чадвар, хүмүүжил, бие хүний сэтгэхүйн ба бие бялдрын хөгжил, ёс суртахууны эерэг шинж чанаруудыг төлөвшүүлж, авъяас билгээ төгөлдөржүүлэн хөгжүүлснээр өөрийгөө бусдад үнэн зөвөөр илэрхийлж сурах нь өнөөгийн нийгэмтэй хөл зэрэгцэн алхах шаардлагад нийцнэ.

Түлхүүр үг: Ардчилал нийгэм, Бие хүн, нийгэмшилт, ардчилалын хөгжлийн явцад бие хүний хувьсан өөрчлөлт, сэтгэл зүй, авъяас

Товч хураангуй: Ардчилсан чөлөөт нийгэмд хүмүүс амьдрахдаа хүн болж төлөвших явцад, хэрхэн авъяасаа хөгжүүлж нийгэмтэйгээ хөл зэрэгцэн алхах, нийгмийн хөгжлийг дагаад өөрийгөө хэрхэн хөгжүүлсэн санааг дэвшүүлсэн болно.

ABSTRACT

Every citizen's an active activity and their knowlesage, talent and also now their personality is formed which is influenced to ensure democratic social criteria. It's very important to live in conformity with the requirement being political politeness.

As well as social range and social organization play main role to involve citizen in politic especially personal psychology, her and his talent ability, education or progress of personal psyche and physique and to form educational positive nowadays it satisfied that learning to express oneself truly to others as result of personal talent and education, physique is perfected.

НОМ ЗҮЙ

1. Даваа.Ж, Жамц.Л, Содов.Ц, Сүхбат.Г. Боловсрол судлалын үндэс. Боловсролын хүрээлэн. Орхон Их Сургууль. УБ.2009. х-61
2. Сарантуяа.Г. Сэтгэц оношлогоо. УБ.2001.х-70.
3. Дэлгэржав.М. Багшийн мэргэжил дээшлүүлэх асуудалд. УБ.2006.х-16
4. Золзаяа.Б//МУИС-НШУС. Боловсрол судлал. УБ.2005.07(255)х-11
5. Золзаяа.М. Ёс зүй. УБ.2005.х-84
6. Даваа.Ж.//МУИС-НШУС. Боловсрол судлал. УБ.341(2010.01) х-51
7. 6-р бүлэг. "Бие хүний сэтгэл зүй"//Сэтгэл судлал. Практик сэтгэл судлалын номын сан. УБ.2002.х-162Айсмонтас.Б.Б.Сургалтын онол. /бүдүүвч, сорил. УБ.2003.х-140Платон. Захидлууд. (Орчуулга. Б.Д) ED.1998.7 дах тал "Дэлхийн түүхийн суут 100 хүн. Майкл Х.Харт. (Орч. Д.Өлгийсайхан)УБ.2010.х-80
8. Программа курса психологий. Сэтгэл судлал. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон тэмдэгт Монгол Улсын Их Сургууль. УБ.1963.х-8
9. "Дэлхийн түүхийн суут 100 хүн. Майкл Х.Харт. (Орч. Д.Өлгийсайхан)УБ.2010.х-100
10. Программа курса психологий. Сэтгэл судлал. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон тэмдэгт Монгол Улсын Их Сургууль. УБ.1963.х-8

11. Базарпүрэв.С.Улс төрийн шинжлэх ухаан. Хураангүй лекц.УБ.2005.х-89-90
12. СЭЗДС-ийн сэтгэл судлалын ухааны доктор, профессор Б.Оюунчимэг
13. The Principles of Marketing. Phillip Kotler.
14. http://en.wikipedia.org/wiki/Consumption_%28economics%29
15. Хенри.Ховард. History of Mongols. It 1.London.1876.,p.49
16. Загджав.Д. Монгол дахь иргэдийн улс төрийн оролцоо, өөрчлөлт. УБ. 2002.,х-41
17. Юриев.А.И.Введению психологию СПб.,1992.с-187
18. Дэлгэржав.М. Багшийн мэргэжил дээшлүүлэх асуудалд. УБ.2006.х-60